



237

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2004 оны 4 сарын 13 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

**Дүрэм, хөтөлбөр баталж дэмжлэг  
үзүүлэх тухай**

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг, дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. "Хөдөлмөр, хүмүүжил-сургалтын төв"-д зохион байгуулалтын өөрчлөлт хийж "Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв" болгон орон тооны дээд хязгаарыг 45 байхаар тогтоосугай.

Хоёр. "Хөдөлмөр, хүмүүжил сургалтын төвийн зохион байгуулалтанд өөрчлөлт орсонтой холбогдуулан Ц.Нарандэлгэрийг 2004 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөр тасалбар болгон Хөдөлмөр, хүмүүжил сургалтын төвийн захирлын үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс эхлэн "Хүүхдийн сургалт, хүмүүжлийн тусгай төв"-ийн захирлаар томилж, сарын үндсэн цалинг 75800 төгрөгөөр, ур чадварын нэмэгдлийг 20 хувиар нэмэгдүүлэхийг тус төвийн нягтлан бодогч Г.Уранчимэгт зөвшөөрсүгэй.

Гурав. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхдийн сургалт, хүмүүжлийн тусгай төвийн дүрмийг 1 дүгээр, зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, хөтөлбөрийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

Дөрөв. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан, ажлын шаардлагыг харгалзан ажилчин, албан хаагчдыг томилж чөлөөлөн цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоохыг Хүүхдийн сургалт, хүмүүжлийн тусгай төвийн захирал /Ц.Нарандэлгэр/-т үүрэг болгосугай.

Тав. Хүүхдийн сургалт, хүмүүжлийн тусгай төвийг Засгийн газрын 1999 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан "Тусгай сургалтын төрийн өмчийн байгууллагын зарим ажилтанд нэмэгдэл хөлс олгох тухай журам"-д хамааруулсугай.

My dok. Zakiramj-04

0200497

Зургаа. Дэлхийн банкны төсөлд хамруулах замаар хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төвийн байранд хэсэгчилсэн засвар хийж, үйл ажиллагаанд нь зайлшгүй шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, техник хэрэгслэлээр хангах арга хэмжээ авахыг Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс /Ш.Наран/-т даалгасугай.

Долоо. Энэ захирамж гарсантай холбогдуулан 1999 оны А/214 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



239

Нийслэлийн засаг даргын 2004 оны 4  
дугаар сарын 13 өдрийн 158  
дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт

## ХҮҮХДИЙН СУРГАЛТ, ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ТӨВИЙН ДҮРЭМ

### Нэг: Нийтлэг үндэслэл:

1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв нь цаашид / тусгай төв гэх / нийслэлийн хэмжээнд эцэг эхийн хараа хяналтаас гарч хүнд нөхцөлд амьдарч байгаа 7-17 насны хүүхдийн эрх ашгийг хамгаалж, тэдэнд боловсрол нөхөн олгох, элдэв муу зуршлаас хөндийрүүлэх, авъяас сонирхлынх нь дагуу дэмжин хөгжүүлэх, эрүүл мэндийг сахин хамгаалах, эцэг эхийн нь оронд халамжлан өсгөн хүмүүжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаанд сургах, гэмт хэрэг, хэв журмын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл төвтэй хөгжлийн чиг баримжааг баримтлан үйл ажиллагаа явуулдаг төрийн үйлчилгээний тусгай байгууллага мөн.

1.2. Тусгай төв нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Хүүхдийн эрхийн хамгаалах тухай хууль, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай хууль, Боловсролын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжууд, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, захирамж, энэ дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Тусгай төв нь үйл ажиллагаандаа хүүхдийн эрх ашгийг хамгаалах, тэднийг хайрлан хүндэтгэх, амьдралын зөв хэвшилд сурган төлөвшүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдыг орлон хүмүүжүүлэх, эцэг эх гэр бүлд нь хүргэж дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэл баримтлана.

1.4 Тусгай төв нь Нийслэлийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж тайлагнана

1.5. Тусгай төв нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж банкинд харилцах данстай байна.

### Хоёр. Тусгай төвийн удирдлага зохион байгуулалт:

2.1. Тусгай төвийн бүтэц орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, захирлыг томилж чөлөөлнө.

2.2. Төвийн захирал эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

2.3. Төвийн захирал нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан төвийн албан хаагч, багш, ажилтнуудыг томилж чөлөөлнө.



2.4. Тусгай төвийн захирлын дэргэд байгууллагын зорилт чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулна. Зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах журмыг төвийн захирал батална.

2.5. Тусгай төвийн захирал нь төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу үр дүнгийн гэрээнд тусгасан бүтээгдэхүүнийг нийлүүлэн төсвийг зарцуулна.

2.6. Тусгай төвийн захирал нь ажилтнуудтайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилтнуудын ажил үүргийн хуваарийг батална.

2.7. Тусгай төв нь дотоод журамтай байна. Уг журмыг хамт олны хурлаар хэлэлцүүлэн захиралын тушаалаар батална

2.7. Тусгай төв нь эрхэлсэн хүрээний асуудлаа бие дааж шийдвэрлэхийн зэрэгцээ шаардлагатай асуудлаар бусад газартай хамтран ажиллана.

2.8. Тусгай төв нь хуваарилагдсан төсөвт зохицуулан суралцагчдыг хоол, ээлжийн хувцас формоор хангана

2.9. Тусгай төвд 7-17 хүртэлх насны орон гэрээсээ дайжсан хараа хяналтгүй хагас ба бүтэн өнчин хүүхдийг Хүүхдийн хаяг тогтоох тасгийн даргын тодорхойлолтоор авна.

2.10. 17 –оос дээш насны хүүхдийг "Амьдрах ухаан сургалт үйлдвэрлэлийн тусгай төв" –д шилжүүлнэ.

2.11. Тусгай төв нь хүүхдийн эцэг эх тэднийг төлөөлөх хүмүүс, холбогдох байгууллага бусад газартай байнгын холбоотой ажиллах ба тэдэнтэй биечлэн уулзах / захидлаар харилцах, уулзалт ярилцлага / зохион байгуулах зэрэг олон хэлбэрийн ажлыг хүүхдийн гэр бүлд нь ойртуулах чиглэлийг баримтлан үйл ажиллагаагаа явуулна

### **Гурав. Тусгай төвийн үүрэг:**

3.1. Тусгай төв нь Монгол Улсын Засгийн Газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

3.2. Холбогдох хууль, тогтоомж, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, үүрэг даалгавар, эдийн засаг нийгмийн зорилтыг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүн нийлүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлт, үр дүнг хугацаанд нь тайлагнана.

3.3. Хүүхдийн эрүүл мэнд, сэтгэл санаа, зан төлөвшлийн нөхөн сэргээх үйлчилгээ явуулна.

3.4. Боловсрол нөхөн эзэмшүүлж, мэргэжлийн чиг баримжааг олгох болон, албан бус сургалтыг явуулна.

3.5 Тусгай төвийн санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааг бэхжүүлэх, хүүхдийг хөдөлмөрт дур сонирхолтой болгох зорилгоор туслах аж ахуй эрхэлж болно .

3.6. Тусгай төвийн хүүхдүүдийн тав тухтай амрах нөхцлийг хангаж хүүхдийн зуслан ажиллуулна.

3.7. Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулна

3.8. Тусгай төв нь Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний дагуу нийслэлийн төсвөөс санхүүжилт авч тайлан мэдээг тогтоосон хугацаанд гаргаж байна.

3.9. Эрхэлж буй ажлын хүрээнд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар баримт бичиг боловсруулан Нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэнэ.

3.10. Тусгай төвийг зохих мэдлэг мэргэжил, дадлага туршлагатай, үнэнч шударга, чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлнэ

3.11. Тусгай төвийн багш, ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, хүүхдүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгох болон амьдрах арга ухаан, хүмүүжил төлөвшлийг бий болгоход чиглэсэн ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор урт, богино хугацааны сургалтуудыг зохион байгуулна

3.12. Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн үйлчилгээний албан хаагч, багшийн ёс зүйг чанд сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хоронгийн хадгалалт хамгаалалт, төсвийн болон хандивын хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулж ажиллана.

3.13. Байгууллагын дотоод дэг журмыг чанд сахиулна

**Дөрөв. Хүүхдийн сургалт, хүмүүжлийн тусгай төв нь дор дурьдсан эрх эдлэнэ.**

4.1. Монгол Улсын болон олон улсын холбогдох хууль тогтоомжинд заагдсан эрх

4.2. Тусгай төвийн төсөв, зээл, тусламж, хандивын хөрөнгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зарцуулна.

4.3. Хүүхдийг асран хамгаалах, сурган хүмүүжүүлэх үүргээ нэр төртэй биелүүлж байгаа тэргүүний багш, ажилтнуудад Засгийн газрын 36 дугаар тогтоолоор батлагдсан Тусгай сургалтын төрийн өмчийн байгууллагын зарим ажилтанд нэмэгдэл хөлс олгох тухай журмын дагуу нэмэгдэл цалин олгох

4.4. Ажиллагсдаас хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг болон ажлын байрны тодорхойлолтонд заагдсан шаардлагаа биелүүлэхийг шаардах, хууль тогтоомжинд заасан хариуцлагыг хүлээлгэх

4.5. Батлагдсан орон тоонд багтаан хамтлаг, туслах аж ахуй, эрхэлж өөрийн орлогоо нэмэгдүүлж болно.

4.6. Гадаад дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай харилцаа холбоо тогтоож хамтран ажиллана

4.7. Ашиглагдахгүй болсон илүүдэлтэй байгаа хэрэгцээ шаардлага хангахгүй болсон материал, эд хогшил, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, хүүхдийн хувцасыг худалдах, шилжүүлэх, актлах, устгах асуудлыг нийслэлийн өмчийн газарт санал оруулан шийдвэрлэнэ.

#### Тав. Хүлээлгэх хариуцлага

Төвийн захирал, ажилтнууд нь бүтээгдэхүүн нийлүүлэх, үр дүнгийн гэрээ болон энэ дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

#### Зургаа. Нэмэлт өөрчлөлт.

Энэ дүрмэнд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь энэхүү дүрмийн салшгүй хэсэг болно.



Нийслэлийн Засаг даргын 2004 оны  
4 дугаар сарын 13 өдрийн 158  
дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХҮҮХДИЙН СУРГАЛТ,  
ХҮМҮҮЖЛИЙН ТУСГАЙ ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ,  
БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**Нэг. Нийтлэг үндэслэл.**

**1.1. Оршил.**

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх хүүхдийн сургалт хүмүүжлийн тусгай төв / цаашид төв гэнэ / -ийн үйл ажиллагааны стратеги, бүтэц, зохион байгуулалтын хөтөлбөр / цаашид хөтөлбөр гэнэ / -т Нийслэлийн Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлж, хараа хяналтаас гарч хүнд нөхцөлд амьдарч байгаа 7-17 насны хүүхдийн эрх ашгийг хамгаалж тэдэнд боловсрол нөхөн олгох, эрүүл мэндийг нь сахин хамгаалах, эцэг эхийн оронд халамжлан өсгөн хүмүүжүүлэх, гэр бүл төвтэй хөгжлийн чиг баримжааг баримтлан, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн нийгмийн хамгааллын талаархи бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, бусад байгууллага, түншүүдтэй харилцах, хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах асуудлыг хамарсан төвийн үйл ажиллагааны стратеги болон бүтцийн загварыг тодорхойлов.

**1.2. Үндэслэл.**

Төлөвлөгөөг доорхи баримт бичигт үндэслэн боловсруулав:

- Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр 2001 он
- Нийслэлийн төрийн байгууллагуудын зорилт, чиг үүрэг, бүтэц үнэлгээ өгөх төсөл / үйл ажиллагааны стратеги, бүтцийн загвар / 1998 он

**1.3. Эрх зүйн орчин.**

Төлөвлөгөөг доор дурьдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол улсын үндсэн хууль
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Нийгмийн халамжийн тухай хууль
- Монгол улсын төрийн албаны тухай хууль
- Монгол улсын төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж

### 1.4. Тусгай төвийн үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь.

Тусгай төв нь Нийслэлийн Засаг даргаас хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлаар дэвшүүлсэн зорилт, бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, хүүхдийн эрх ашгийг хамгаалах мэргэжлийн чиг баримжааг олгох, амьдрах арга ухаанд сургах, гэмт хэрэг хэв журмын зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, гэр бүл төвтэй хөгжлийн чиг баримжааг баримтлан холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

### 1.5. Стратегийн хэрэгжилтийг хангах бүдүүвч

Тусгай төвийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурьдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана.



Тусгай төвийн стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурьдсан хэрэглээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгчдэд тулгуурлан Нийслэлийн



Засаг даргад нийлүүлэх бүтээгдэхүүнийг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэнэ. Энэхүү хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ төрөл хэлбэрийг нийлүүлэх бүтээгдэхүүн тус бүрээр тогтоон төвийн зорилт, чиг үүрэг, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтоор нарийвчлан тогтоож хэрэгжүүлнэ.

## **Хоёр. Тусгай төвийн үйл ажиллагааны стратеги.**

### **2.1. Стратегийн мөн чанар.**

Тусгай төвийн үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь тус төвийн эрхэм зорилго, зорилтыг тодорхойлж, нийслэлийн хэмжээнд гэр орноосоо дайжсан хараа хяналтгүй хүүхдийг төлөвшүүлэн хөгжүүлж мэргэжлийн чиг баримжаа олгох идэвхитэй бодлогыг хэрэгжүүлэхэд оршино.

### **2.2. Үйл ажиллагааны эрхэм зорилго.**

#### **Тусгай төвийн эрхэм зорилго:**

Хүүхэд, хүүхдийн нийгмийн хамгааллын талаархи төрийн бодлого, Засгийн газар, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хотөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлж биелэлтийг хангах, гэр бүл төвтэй хөгжлийн чиг баримжааг баримтлан мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### **2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт**

- 2.4.1. Гэр орноосоо дайжсан, хараа хяналтгүй хүүхдүүдэд боловсрол нөхөн олгож , амьдрах арга ухаанд сурган, зан төлөвийг нь төлөвшүүлж, мэргэжлийн чиг баримжаа олгох
- 2.4.2. Хараа хяналтгүй хүүхдүүдийг гэр бүл, эцэг эхэд нь хүлээлгэн өгч гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх
- 2.4.3. Гэр оронгүй тэнэмэл амьдралтай эмзэг бүлгийн хүүхдүүдийг нийгэмшүүлэх
- 2.4.4. Хөдөлмөр, сургалтын арга хэмжээний төсөв, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зарлага санхүүжилтыг зүй зохистой явуулах
- 2.4.5. Төвийн оновчтой, зөв бүтэц бүрдүүлэх, удирдлагын чадавхийг дээшлүүлж үр өгөөжийг дээшлүүлэх